## "БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ОНӨТҮГ
## 2021 ОНЫ 07 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**2021 оны 07 дугаар сарын 30-ны өдөр** **Багануур дүүрэг**

| № | ҮНДЭСЛЭЛ | ХИЙСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ |
|---|---|---|---|
| 1. | БҮТП-ийн Ерөнхий төлөвлөгөө, инженерийн шугам сүлжээний зураг төсөл | - Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүрэг, МУЗГ-ын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 6.1.11.3, НЗД-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.2.2 дахь заалтын хүрээнд паркийн гадна инженерийн шугам сүлжээний зураг төслийн цахилгааны хэсгийг баталгаажуулах явцад хяналт тавьж байна.<br>1. Паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 7,3 км урт агаарын шугам, 110/35/10 кВ-ын дэд станцын батлагдсан зураг төслийн төсөв Эрчим хүчний яамны эрчим хүчний хөгжлийн төвийн төсвийн магадлангаар хянагдаж баталгаажсан.<br>2. Паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн цахилгаан хангамжийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн 4,6 км урт агаарын шугам, 35/10 кВ-ын дэд станцын батлагдсан зураг төслийн төсөв Эрчим хүчний яамны эрчим хүчний хөгжлийн төвийн төсвийн магадлангаар хянагдаж баталгаажсан.<br>Дээрх зураг төслүүдэд тус яамны магадлангийн нэгдсэн дүгнэлт гаргах ажил хүлээгдэж байна. | 93% |
| 2. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1.2 | НЗД-ын 2021 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/483 дугаар захирамжийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд:<br>- 2021 оны 07 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд холбогдох яамд, НЗДТГ, НШУШИГ, ҮТП-ийн удирдлагууд, мэргэжилтнүүдийн хамт хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулах саналуудын талаар хэлэлцсэн.<br>- 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдөр дээрх газруудын төлөөллүүд дахин цахимаар хуралдаж ҮТП-ийн үйл ажиллагаа, тулгамдаж байгаа асуудлуудтай танилцсан.<br>- Ажлын хэсгээс урьдчилсан байдлаар боловсруулсан Ажлын хэсгийн төлөвлөгөөний 1.2.2, 2.2.1, 2.2.2 дахь заалтуудын хүрээнд тусгах санал, НЗД-ын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэн НШУҮИГ-ын холбогдох мэргэжилтний ERP чатаар хүргүүлсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2.4 | - БНХАУ-ын ЭСЯ-наас 2021 оны 07 дугаар сарын 09-19-ний өдрүүдэд цахимаар зохион байгуулсан Аж үйлдвэрийн парк байгуулах, бусад орнуудын туршлагын талаарх сургалтад Захиргааны албаны Ахлах мэргэжилтэн, Бичиг хэрэг, архив, гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн нар хамрагдсан.<br>- Нийслэл болон дүүргийн Засаг даргын Хотын соёл аяныг зохион байгуулах удирдамжийн дагуу "Соёлч иргэний 10 зөв дадал" сургалтыг албан хаагчдын дунд зохион байгуулж, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулсан. | 100% |
| 4. | Нийслэлийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/1054 дүгээр захирамж | - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системийг ашиглах журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- 2021 оны 07 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хариутай 6, хариугүй 2 нийт 8 албан бичиг ирсэн. Албан бичгийн шийдвэрлэлт, хаалт тус бүр 100%. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3.13<br>- 2021 оны 07 дугаар сарын байдлаар "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-аас ААНБ-уудад нийт 8 хариугүй бичиг явуулсан. Шийдвэрлэлт-100%<br>- 7 дугаар сард ээлжийн амралт авч байгаа 2 албан хаагчийн мэдээллийг ERP системд оруулж амралтыг бүртгэлжүүлсэн. | 100% |
| 5. | ЗГ-ын 2009 оны 143, 2013 оны 411 дүгээр тогтоол | - 2021 оны 07 дугаар сарын байдлаар байгууллагын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 8, цар тахалтай холбоотой 23 мэдээллийг байршуулсан. | 100% |
| 6. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль | - www.shilendans.mn сайтанд байгууллагын санхүүгийн мэдээллийг агуулга стандартын дагуу байршуулж санхүүгийн 2 дугаар улирлын тайланг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр илгээсэн.<br>- Байгууллагын үйл ажиллагааны төсвийн 2021 оны 07 дугаар сарын зарцуулалтын гүйцэтгэлийг НТСХ-ийн хяналтанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хангаж, санхүүгийн сарын мэдээг хугацаанд нь тайлагнаж ажиллав.<br>- "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ын 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөллийг 2021 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон холбогдох эдийн засгийн тооцоо судалгаанд үндэслэн зохих хавсралт маягтуудын дагуу боловсруулж 2021 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 111 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн. | 100% |
| 7. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1.1 | - Ажилтнуудыг ажлын байранд нэвтрэхээс өмнө түрээслүүлэгч компанийн ажилтан биеийн халууныг хэмжиж, гарыг халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Ажлын байранд хүний гар хүрэх газрыг 2 цаг тутамд ариутгаж, өдөр бүр агааржуулалтыг хийн, 7 хоногт нэг удаа их цэвэрлэгээг зохион байгуулан ажиллаж байна.<br>- Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх QR кодыг иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулан хэрэгжилтэнд шууд хяналт тавьж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | - "Ковид 19 эрсдэл систем"-ийг бүх албан хаагчдад гар утсандаа суулган ашиглаж байна.<br>- Бүх албан хаагчид коронавирусын эсрэг дархлаажуулалтын 2 дахь тунд хамрагдсан.<br>- 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн байгууллагад коронавирусын халдвар бүртгэгдсэн эсэх судалгааг загвар хүснэгтийн дагуу гаргаж, 7 хоног бүрийн 1,3,5 дахь өдрүүдэд мэдээг шинэчлэн НЗДТГ-ын Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтний ERP чатад хүргүүлэн ажиллаж байна.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 115, 118 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/477 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| | НЭМЭЛТ АЖИЛ | | |
| 8. | НУАШХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг НЗДТГ-ын О.Мандах мэргэжилтэн рүү хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. | | 100% |
| 9. | Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны тайланг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Пүрэв гарагт НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст тайлагнаж байна. | | 100% |
| 10. | Монгол Улсын төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.2 дахь зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хотын соёл" аяныг "Соёлтой БолГоё" уриатайгаар 2021 оны 06 дугаар сарын 21-нээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний хооронд зохион байгуулах удирдамжийн дагуу "Хотын соёл" аяныг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөөг батлан, 7 дугаар сард хэрэгжүүлсэн ажлын тайланг 07 дугаар сарын 26-ны өдөр 112 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Соён гэгээрүүлэх тасагт хүргүүлсэн. | | 100% |
| 11. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд амралтын өдрүүдэд /07 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд/ ажиллах хариуцлагатай эргүүл жижүүр ажиллуулах үүргийн дагуу хариуцлагатай жижүүрийн хуваарийг гаргаж түрээслүүлэгч "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХХК-нд өгч хуваарьт өдрүүдэд хяналт тавьж ажилласан. | | 100% |
| 12. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүрэг, байгууллагын чадавхын судалгаа хийж байгаатай холбогдуулан дараах материалуудыг нэгтгэж Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 107 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст, local.governance.ub@gmail.com хаягт тус тус хүргүүлэв.<br>- Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт<br>- Албан тушаалын тодорхойлолтыг баталсан Газрын даргын шийдвэр<br>- Ажлын байрны ачааллын шинжилгээ | | 100% |
| 13. | Засгийн газрын 2020 оны 96 дугаар захирамжийг хэрэгжүүлэх тусгай төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үүднээс Газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод монгол бичгийн мэдлэг чадварыг нэмж тусган, албан тушаалын тодорхойлолтод орсон өөрчлөлтийг албан хаагчдад танилцуулсан. | | 100% |
| 14. | Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд тусгуулах шинээр хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмжийн саналыг, маягтын дагуу боловсруулж Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 106 дугаартай албан бичгээр НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, nzdtghbth@gmail.com мэйл хаягт тус тус хүргүүлэв. | | 100% |

| | | |
|---|---|---|
| 15. | Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор дүүргийн хэмжээнд зохион байгуулсан "Шийдэл" бодлогын хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан зөвлөмж, төлөвлөгөөг байгууллагын Гэр бүл, хүүхэд, залуучуудын салбар зөвлөлийн гишүүд болон албан хаагч нарт танилцуулж, төлөвлөгөөний биелэлтийн тайланг заасан хугацаанд гаргаж дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтэст хүргүүлж ажиллахаар болсон. | 100% |
| 16. | "Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай" Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2021 оны 03 дугаар зөвлөмжийг албан хаагч нарт танилцуулж, хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв. | 100% |

УЛААНБААТАР ХОТ
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
УГ 0014 3184062
2015 109064

ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч. ЭЛБЭГСАЙХАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Э.ЭНХЗАЯА